



МОНГОЛ УЛСЫН
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
УЛСЫН КОМИССЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын
өдрийг хүндэтгэн өнгөрүүлэх тухай

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 1996 оны 33 дугаар тогтоол, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрмийн 4 дүгээр зүйлийн 18 дугаарт заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх 28 дахь өдрийг хүндэтгэн өнгөрүүлсүгэй.
2. Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулан, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр, аймаг, нийслэлийн салбар комиссын дарга нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөрт даалгасугай.

ДАРГА



С.ОДОНТУЯА